

ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

“МИГ ДААТГАЛ” ХХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД

Бид “Миг Даатгал” ХХК-ийн 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо тайлан, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгэлээ.

Санхүүгийн тайлангийн талаарх удирдлагын хүлээх хариуцлага

Санхүүгийн тайланг Санхүүгийн тайлагналын Олон Улсын Стандартын (цаашид СТОУС гэх) дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах нь компанийн удирдлагын үүрэг хариуцлага юм. Алдаа, зальт ажиллагааны улмаас материаллагаар буруу илэрхийлэгдээгүй санхүүгийн тайланг бэлтгэж, үнэн зөв толилуулахтай холбоотой дотоод хяналтыг төлөвлөх, хэрэгжүүлэх, мөрдөх ба нягтлан бодох бүртгэлийн зохих бодлогуудыг сонгон авч хэрэглэх, тухайн нөхцөл байдалд уялдан нягтлан бодох бүртгэлийн тооцооллыг хийх зэрэг нь энэхүү хариуцлагад хамаарна.

Санхүүгийн тайлангийн талаархи аудиторовн хариуцлага

Хийсэн аудитын ажилдаа үндэслэн санхүүгийн тайланд хараат бус байдлаар дүгнэлт гаргах нь аудитор бидний үүрэг хариуцлага юм. Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандартын дагуу гүйцэтгэсэн. Аудитын Олон Улсын Стандартын дагуу бид санхүүгийн тайлан нь материаллаг алдаагүй илэрхийлэгдсэн талаархи хүчин төгөлдөр хангалттай нотолгоог олж авахын тулд аудитаа төлөвлөж гүйцэтгэх ба ёс зүй шаардлагыг дагаж мөрддөг.

Санхүүгийн тайлан дахь дүн болон тодруулгын талаархи аудитын нотолгоог авахын тулд горимуудыг гүйцэтгэх нь мөн аудитын ажилд багтдаг.

Хараат бус аудиторын дүгнэлт (үргэлжлэл)

Горимын сонголт нь аудиторын мэргэжлийн үнэлэлт дүгнэлтээс хамаарах бөгөөд үүнд залилан буюу алдааны улмаас санхүүгийн тайланг материаллагаар буруу илэрхийлэх нь эрсдлийн үнэлгээнд хамаарна.

Тэдгээр эрсдлийн үнэлгээг хийхдээ аудитор нь компанийн дотоод хяналтын үр дүнтэй байдлын талаар дүгнэлт гаргах биш, харин тухайн нөхцөл байдалд зохистой аудитын горимуудыг төлөвлөх үүднээс компанийн санхүүгийн тайлангуудаа бэлтгэн үнэн зөв толилуулахтай холбоотой дотоод хяналтыг авч үздэг.

Мөн компанийн удирдлагын хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын зохистой байдал, хийсэн материаллаг тооцооллын үндэслэл болон санхүүгийн тайлангуудын ерөнхий тайлагналын байдалтай аудитын явцад танилцсан. Хэрэв бид ямар нэг илэрхий материаллаг буюу үл тохирох алдаа илрүүлсэн бол аудитын тайландаа тусгадаг.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудитын дүгнэлт гаргахад хангалттай, зохих үндэслэл болно гэдэгт бид итгэж байна.

Дүгнэлт

Бидний дүгнэлтээр, аудитласан санхүүгийн тайлангууд нь "Миг Даатгал" ХХК-ийн 2014 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөрх санхүүгийн байдал, тухайн өдрөөр дуусгавар болсон үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартад нийцүүлэн, Санхүүгийн Зохицуулах Хорооноос баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн байна.



N. Bayar
Энэбишийн Нинждулам
Гүйцэтгэх Захирал
ЮДЕНТАКС ТИИ АУДИТ ХХК

